



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын 14 дүгээр Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДОА-2022/145/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот  
2022 он

*Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул*

*Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn*

*Аудитын менежер: И.Сэмжидмаа*

*Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn*

*Ахлах аудитор: Д.Нармандах*

*Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn*

*Аудитор: А.Даваасүрэн*

*Утас: 70003775, 88883776*

*Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com*

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.6.1 Төсвийн төлөвлөлт .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	<b>Error! Bookmark not defined.</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1. Аудитын санал дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.2.25 № 261

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН  
14 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Х.НАРАНТУЯА ТАНАА

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020146

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>130,141,147.60</u></b>	<b><u>142,830,116.19</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,677,054.51	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,677,054.51	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	128,464,093.09	142,830,116.19
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	-	529,500.00
35130	Эм боох материал	-	529,500.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	128,464,093.09	142,300,616.19
35410	Бичиг хэргийн материал	116,000.00	590,300.00
35420	Аж ахуйн материал	-	138,000.00
35470	Бусад хангамжийн материал	128,348,093.09	141,572,316.19
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,196,969,611.33</u></b>	<b><u>2,238,802,673.88</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,196,969,611.33	2,238,802,673.88
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,945,954,611.33	1,987,650,173.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,960,775,761.84	2,049,509,354.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	(81,646,824.00)	(125,962,475.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	61,924,161.50	61,924,161.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(49,939,561.52)	(53,662,821.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	50,235,106.00	50,235,106.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,885,826.56)	(37,319,288.04)
39214	Бусад үндсэн хөрөнгө	66,833,801.00	78,273,801.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(31,342,006.93)	(35,347,664.05)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	251,015,000.00	251,152,500.00
39301	Программ хангамж	1,111,000.00	1,413,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(946,000.00)	(1,111,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	250,850,000.00	250,850,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,327,110,758.93</u></b>	<b><u>2,381,632,790.07</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>1,677,054.51</u></b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,677,054.51	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,677,054.51	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,677,054.51	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,677,054.51	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,325,433,704.42</u></b>	<b><u>2,381,632,790.07</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,325,433,704.42	2,381,632,790.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	600,973,993.50	600,973,993.50
51101	Өмч: - төрийн	350,123,993.50	350,123,993.50
51103	- хувьцаат	250,850,000.00	250,850,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	9,281,951.51	65,481,037.16
51210	Өмнөх үеийн үр дүн	9,281,951.51	9,281,951.51
51220	Тайлант үеийн үр дүн	-	56,199,085.65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,715,177,759.41	1,715,177,759.41
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,327,110,758.93</u></b>	<b><u>2,381,632,790.07</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>634,194,225.75</b>	<b>715,225,474.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>88,418,625.75</b>	<b>112,770,093.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	24,349,732.75	112,770,093.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,349,732.75	112,770,093.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,349,732.75	112,770,093.00
<b>121</b>	<b>Хөрөнгийн орлого</b>	64,068,893.00	-
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	64,068,893.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>26,094,100.00</b>	<b>66,534,181.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	519,681,500.00	535,921,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,640,000.00	39,042,881.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,640,000.00	39,042,881.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	24,454,100.00	27,491,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,454,100.00	27,491,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>599,799,452.99</b>	<b>659,026,388.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>599,799,452.99</b>	<b>659,026,388.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	579,137,973.35	606,194,757.88
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	405,010,700.00	421,945,472.21
210101	Үндсэн цалин	306,664,852.71	315,007,791.51
210102	Нэмэгдэл	70,172,881.29	76,609,155.00
210104	Урамшуулал	28,172,966.00	30,328,525.70
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	50,549,385.36	56,742,645.34
210201	Тэтгэврийн даатгал	34,380,727.36	39,916,149.74
210202	Тэтгэмжийн даатгал	4,042,048.00	4,378,841.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,233,783.00	3,461,548.67
210204	Ажилгүйдлийн даатгал	808,530.00	816,755.16
210205	Эрүүл мэндийн даатгал	8,084,297.00	8,169,350.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21,671,378.00	25,663,065.98
210301	Гэрэл, цахилгаан	4,843,538.00	3,752,158.70
210302	Түлш, халаалт	11,701,379.00	16,104,461.28
210303	Цэвэр, бохир ус	5,126,461.00	5,806,446.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,356,889.00	9,283,264.90
210401	Бичиг хэрэг	496,500.00	765,900.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	355,800.00	544,500.00
210404	Ном, хэвлэл	-	231,090.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	510,800.00	874,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	345,600.00	1,391,350.00
210408	Бараа материал акталсны зардал	1,148,189.00	5,276,424.90
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	37,771,275.00	32,048,879.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	161,600.00	1,678,603.00
210502	Хоол, хүнс	37,609,675.00	30,370,276.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	43,360.00	-
210604	Урсгал засвар	43,360.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	48,000.00	100,000.00
210702	Дотоод албан томилолт	48,000.00	100,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	43,400.00	506,052.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	43,400.00	506,052.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	60,643,585.99	59,905,378.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	598,782.00	1,262,348.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,544,803.99	58,643,030.45
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	20,661,479.64	52,831,630.47
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	100,000.00	39,174,178.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	22,579,986.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	15,983,292.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	610,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	20,561,479.64	13,657,452.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,561,479.64	13,657,452.47
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>34,394,772.76</u></b>	<b><u>56,199,085.65</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	3,551,554.16	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,551,554.16	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(3,551,554.16)	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>30,843,218.60</u></b>	<b><u>56,199,085.65</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	600,973,993.50	1,715,177,759.41	9,281,951.51	2,325,433,704.42
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	600,973,993.50	1,715,177,759.41	9,281,951.51	2,325,433,704.42
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	600,973,993.50	1,715,177,759.41	9,281,951.51	2,325,433,704.42
Тайлант үеийн үр дүн	-	-	56,199,085.65	56,199,085.65
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	600,973,993.50	1,715,177,759.41	65,481,037.16	2,381,632,790.07

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>545,775,600.00</b>	<b>602,455,381.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>545,775,600.00</b>	<b>602,455,381.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	519,681,500.00	535,921,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,640,000.00	39,042,881.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,640,000.00	39,042,881.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	24,454,100.00	27,491,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	24,454,100.00	27,491,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>545,775,600.00</b>	<b>602,455,381.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>545,775,600.00</b>	<b>602,455,381.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>525,114,120.36</b>	<b>549,623,750.53</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	405,010,700.00	421,945,472.21
210101	Үндсэн цалин	306,664,852.71	315,007,791.51
210102	Нэмэгдэл	70,172,881.29	76,609,155.00
210104	Урамшуулал	28,172,966.00	30,328,525.70
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	50,549,385.36	56,742,645.34
210201	Тэтгэврийн даатгал	34,380,727.36	39,916,149.74
210202	Тэтгэмжийн даатгал	4,042,048.00	4,378,841.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,233,783.00	3,461,548.67
210204	Ажилгүйдлийн даатгал	808,530.00	816,755.16
210205	Эрүүл мэндийн даатгал	8,084,297.00	8,169,350.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	21,671,378.00	25,663,065.98
210301	Гэрэл, цахилгаан	4,843,538.00	3,752,158.70
210302	Түлш, халаалт	11,701,379.00	16,104,461.28
210303	Цэвэр, бохир ус	5,126,461.00	5,806,446.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,656,000.00	7,668,690.00
210401	Бичиг хэрэг	458,600.00	934,900.00
210402	Тээвэр, шатахуун	500,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	351,300.00	544,500.00
210404	Ном, хэвлэл	281,100.00	231,090.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	510,800.00	874,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,554,200.00	4,884,200.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	39,730,275.00	33,147,677.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	161,600.00	1,109,603.00
210502	Хоол, хүнс	37,609,675.00	30,370,276.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,959,000.00	1,667,798.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	700,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	700,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	48,000.00	100,000.00
210702	Дотоод албан томилолт	48,000.00	100,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	208,400.00	1,310,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	208,400.00	1,310,000.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,539,982.00	1,546,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,039,982.00	1,546,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,661,479.64</b>	<b>52,831,630.47</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	100,000.00	39,174,178.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	22,579,986.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	15,983,292.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	610,900.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	20,561,479.64	13,657,452.47
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,561,479.64	13,657,452.47

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	563,412,500.00	549,755,047.53
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	563,412,500.00	549,755,047.53
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	562,801,600.00	549,144,147.53
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	431,175,900.00	421,945,472.21
210101	Үндсэн цалин	328,589,600.00	315,007,791.51
210102	Нэмэгдэл	70,625,900.00	76,609,155.00
210104	Урамшуулал	31,960,400.00	30,328,525.70
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	57,361,700.00	56,742,645.34
210201	Тэтгэврийн даатгал	40,114,900.00	39,916,149.74
210202	Тэтгэмжийн даатгал	4,311,700.00	4,378,841.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,449,400.00	3,461,548.67
210204	Ажилгүйдлийн даатгал	862,100.00	816,755.16
210205	Эрүүл мэндийн даатгал	8,623,600.00	8,169,350.75
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,991,300.00	25,663,065.98
210301	Гэрэл, цахилгаан	3,767,300.00	3,752,158.70
210302	Түлш, халаалт	16,417,400.00	16,104,461.28
210303	Цэвэр, бохир ус	5,806,600.00	5,806,446.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,538,700.00	7,538,690.00
210401	Бичиг хэрэг	934,900.00	934,900.00
210402	Тээвэр, шатахуун	150,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	594,500.00	544,500.00
210404	Ном, хэвлэл	231,100.00	231,090.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	874,000.00	874,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,754,200.00	4,754,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	36,277,800.00	32,798,074.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	760,000.00	760,000.00
210502	Хоол, хүнс	33,850,000.00	30,370,276.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,667,800.00	1,667,798.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	100,000.00	100,000.00

210702	Дотоод албан томилолт	100,000.00	100,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,310,000.00</b>	<b>1,310,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,310,000.00	1,310,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,546,200.00</b>	<b>1,546,200.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,546,200.00	1,546,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>610,900.00</b>	<b>610,900.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>610,900.00</b>	<b>610,900.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	610,900.00	610,900.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>563,412,500.00</b>	<b>549,755,047.53</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>535,921,200.00</b>	<b>522,263,747.53</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	535,921,200.00	522,263,747.53
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>27,491,300.00</b>	<b>27,491,300.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	27,491,300.00	27,491,300.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>39,042,881.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>39,042,881.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>479,603.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>130,000.00</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	130,000.00
<b>2105</b>	<b>Нормативд зардал</b>	<b>349,603.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	349,603.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>38,563,278.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>38,563,278.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,579,986.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,983,292.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>39,042,881.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>39,042,881.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,042,881.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэрлэн сумын 14 дүгээр Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Нандинчимэг, аудитор А.Даваасүрэн нар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэрлэн сумын 14 дүгээр Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь Сургуулийн өмнөх боловсролын сургалтын чанарыг эрхэмлэж, хүүхэд бүр өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь, чадвар эзэмшихэд үйл ажиллагаагаа чиглүүлэн, цэцэрлэгийн гадна, дотор ногоон орчныг нэмэгдүүлж ногоон эко цэцэрлэг болох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй боловч 2018 онд Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг байгууллагын удирдлага хэрэгжүүлэн ажилладаг байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэрлэн сумын 14 дүгээр Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 төсвийн гүйцэтгэлийн тайлангаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны батлагдсан төсөвт зардлын дүн 523,574.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,853.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,890.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Бараа материалын дансны үлдэгдэл 142,830.1 мянган төгрөг болж 14,366.0 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалттай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,492,206.0 мянган төгрөг болж 100,476.0 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн данс нь орон нутгийн хөрөнгө оруулалтаар 88,733.5 мянган төгрөгийн барилга байгууламж, 11,440.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан бусад үндсэн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 81,031.2 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болон орон нутгаас хуваарилсан мөнгөн хөрөнгөтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 59,227.0 мянган төгрөгөөр өссөн нь бараа, ажил үйлчилгээний зардал өссөнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 549,755.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 549,755.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 549,755.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 535,921.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 27,491.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 27,491.3 мянган төгрөг, улсын төсвөөс 535,921.2 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 563,412.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 549,755.0 мянган төгрөг буюу 97.5 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд 13,657.4 мянган төгрөг буюу 2.4 хувийг татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хэрлэн сумын дээд шатны төсвийн захирагчаас 39,043.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 479.6 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 15,983.3 мянган төгрөг, тэтгэвэр гарахад олгох нэг удаагийн тэтгэмжид 22,580.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хэрлэн сумын 14 дүгээр Цэцэрлэг нь 2021 онд Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 2 орлогын 65,086.3 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх” гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад зөвлөмж өглөө.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17 -ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасны дагуу бүх шатны

байгууллагын төсөв захирагч буюу эрхлэгч тушаал шийдвэр гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаагүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,745.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,745.2 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

### 4.1 Зөвлөмж

1. *Илрүүлэлт:* Тайлант онд 1,745.2 мянган төгрөгийн худалдан авалтын НӨАТ-ын төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх ба эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Худалдан авалтын ажил гүйлгээний төлбөрийн цахим баримтыг бэлтгэн нийлүүлэгчээс бүрэн гаргуулан авах, татварын цахим системээр худалдан авалтыг тухай бүрэн хянаж ажиллах

Дээрх биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын эр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хэрлэн сумын 14 дүгээр цэцэрлэг	2	1.7	-	-	-	-	-	-	2	1.7